

Сурагчдын NSWEdUChat-д хандах журам

Эцэг эх, асран хамгаалагч нарт зориулсан мэдээлэл

NSWEdUChat Шинэ Өмнөд Уэльс мужийн Боловсролын яам (NSW Department of Education)-ны өмч бөгөөд уг яамнаас боловсруулан гаргасан, хиймэл оюун ухаан дээр түшиглэсэн боловсролын сурах хэрэгсэл юм. Энэ хэрэгслийг аюулгүй, боловсролын зориулалттай ашигладаггүйц, найдвартай, нууцлалтайгаар бүтээсэн болно.

Сурагчдын NSWEdUChat-д хандах журам

2025 оны 4-р улирлаас эхлэн 5–12-р ангийн сурагчид NSWEdUChat-д хандах ашиглах боломжтой болно.

NSWEdUChat ашиглаж буй сурагчдын аюулгүй байдал

NSWEdUChat-ийн өгөгдөл найдвартай хамгаалагдсан. Бүх өгөгдөл зөвхөн Боловсролын яаманд хадгалагдах болно. Энэ нь сурагчид өөрсдийн хийсэн хичээл болон хувийн мэдээллээ NSWEdUChat-д итгэлтэйгээр, аюулгүй байдлаар оруулах боломжтой гэсэн үг юм.

NSWEdUChat-ийн сургалтын зориулалт бүхий загвар

NSWEdUChat нь сурагчийн асуусан асуултад шууд бүрэн хариулт өгдөггүй. Харин сурагчдад нээлттэй асуулт тавих маягаар хариу өгдөг. Ингэснээр сурагчдыг өөрсдийн бодол санаа, тэдгээрийн үндэслэлийг гүнзгийрүүлэн судалж, хуваалцахыг нь тус хэрэгсэл урамшуулдаг. NSWEdUChat нь зөвхөн текст ашигладаг. Өөрөөр хэлбэл, зураг, видео, эсвэл хөгжмийн гэх зэрэг медиа бүтээх боломжгүй гэсэн үг юм.

Гэрийн даалгавар болон бие даасан ажил хийхдээ NSWEdUChat-ийг ашиглах нь

Хэрэв сургуулиас NSWEdUChat-ийг гэрийн даалгавар болон бие даасан ажилд ашиглаж болохыг зөвшөөрсөн тохиолдолд, сурагчид тухайн даалгаврыг хийхдээ NSWEdUChat-ийг ашигласан эсэхээ багшдаа мэдэгдэх ёстой. Үүнд, жишээлбэл, хичээлийн тэмдэглэл хураангуйлсан товчлол хийх, гол нэр томъёо ухагдхууныг тодорхойлох, эсвэл текст материалын зөв бүтэцтэй болгох зэрэг ажлуудыг NSWEdUChat-ийн тусламжтайгаар хийсэн эсэх багтана. Сурагчид үүнийг багшдаа ямар байдлаар, хэрхэн мэдэгдэх боломжтой талаар тодорхой мэдээллийг сургуулиас өгөх ёстой.

Гэрээс NSWEdUChat-д хандах боломж

Сурагчид NSWEdUChat-д гэрээсээ дараах холбоосоор орж холбогдож болно:

- Сурагчийн портал: <https://portal.education.nsw.gov.au/>
- Шууд хандалт: chat.education.nsw.gov.au

Сурагчид NSWEdUChat-д нэвтрэхдээ NSW Department of Education-ий нэвтрэх эрхээ ашиглана. Нэвтрэсэн сурагч зөвхөн өөрөө NSWEdUChat-ийг ашиглах ёстой.

Хэрэв та энэхүү хэрэгслийн талаар ямар нэгэн асуулт байвал сургуулийн захиралтай холбогдоно уу.



NSWEdUChat parental privacy notice (NSWEdUChat-ийн эцэг эхчүүдэд зориулсан мэдээллийн нууцлалын мэдэгдэл)-тэй танилцах болон нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл: [Сурагчдын NSWEdUChat-г ашиглах журам](#) хэсгээр орж үзнэ үү

Утсан орчуулгын үйлчилгээ (TIS): 131 450

Хэрэв танд орчуулагчийн туслалцаа хэрэгтэй бол TIS-тэй холбогдон, танд ямар хэл дээр орчуулагч хэрэгтэй, мөн та ямар дугаарт холбогдохыг хүсэж байгаагаа хэлнэ үү. Оператор таныг холбож, мөн танд туслах орчуулагчийг уг шугаманд холбох болно. Энэхүү үйлчилгээ нь үнэ төлбөргүй.